



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/04

Чингис хот

Бүтэц, дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.17, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8, Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоол, 2018 оны 171 дүгээр тогтоол, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2015 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн А-76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийг түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгох Засгийн газрын шийдвэр гарсантай холбогдуулан аялал жуулчлалыг бодлого зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтэц, орон тоог 1 дүгээр хавсралт, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, баталж, мөрдүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Дархантөр/-д даалгасугай.

3. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдан чиглүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

4. Захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн Б/18 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010055

Удирдах ажилтан -3, гүйцэтгэх-42, үйлчилгээний-5, нийт 50 орон тоо
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь "цаашид "газар" гэнэ/ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 01 дугаар сарын 12-ний өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц орон тоо удирдлагын бүдүүвчийн дагуу байгуулагдсан аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж сум орон нутаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд мэргэжлийн арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий орон нутгийн төрийн захиргааны байгууллага мөн.

1.2. Газрын үндсэн зорилго нь Байгаль орчин, аялал жуулчлалын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх менежментийн ур чадварыг нэвтрүүлэх орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан зохион байгуулах, байгаль орчин болон аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх болон сургалт, сурталчилгаа, мэргэжлийн арга зүйн зөвлөлгөөгөөр үйлчлэх ажлыг гүйцэтгэх, зохицуулах, ус цаг уур орчны шинжилгээний ажил, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, хамгаалахад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн оролцоо, нөхөрлөлд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментэд тулгуурласан байгаль орчин, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн үзэл, баримтлал зарчмыг орон нутагт хэрэгжүүлэхэд оршино.

1.3. Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагууд, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын бодлого, тогтоол шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгон Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад, сав газрын захиргаа, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэстэй ажлын уялдааг хангаж, Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бүхий л үйл ажиллагааг аймгийн бусад төрийн захиргааны байгууллага, сум, орон нутаг, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын нэгдмэл ажиллагаатай уялдуулах, тэдний дэмжлэг, идэвхитэй оролцоотойгоор аймгийн хэмжээнд байгаль орчин, байгалийн нөөцийн менежментийг хамтын хүчээр явуулах ажлыг зохицуулна.

1.4. Газар нь ногоон хөгжил, ногоон эдийн засгийн мөн чанар, бодлого зорилтыг эдийн засаг аж ахуйн бүхий л салбар иргэд аж ахуйн нэгж, сум орон нутаг, төрийн албан хаагч, хувийн хэвшлийнхэн зэрэг нийгмийн бүлэг бүрийн боловсролын түвшин, ашиг сонирхол, үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагын онцлогтой уялдуулан нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжих, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил арга зүйн зөвлөгөө удирдамжаар хангах хэрэглэгчдэд байгаль орчин болон хүний эрүүл, аюулгүй байдалд холбогдолтой мэдээллээр хангаж, бүх нийтийн экологийн боловсрол, хүмүүжлийг тогтвортой дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

1.5. Газар нь нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх, бүлэг, хамтлаг, нөхөрлөлийн чадавхийг бэхжүүлэх, хувийн хэвшлийнхний байгалиа хайрлах, хамгаалах сайн дурын идэвхи санаачлагыг өрнүүлэх, байгаль орчинд ээлтэй техник технологи, сайн туршлагыг нэвтрүүлэх, үнэлэх, урамшуулах ажлыг зохион байгуулна.

1.6. Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл

хуудас хэрэглэх ба банкинд харилцах данстай байна.

Хоёр: Газрын удирдлага, бүтэц

2.1. Газрын даргыг Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

2.2. Газар нь салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг зохицуулан уялдуулах зорилгоор зөвлөх эрх бүхий даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг ажиллуулах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд Цаг уур орчны шинжилгээний төвийн захирал, Газрын албаны дарга болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга, Сав газрын захиргааны дарга, аймгийн хөгжлийн бодлогын хэлтсийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнийг оруулна. Зөвлөлийг газрын дарга удирдаж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг өөрийн тушаалаар батална.

2.3. Газрын бүтэц, орон тоонд ойн асуудал хариуцсан нэгж (Ойн алба), аялал жуулчлал хариуцсан нэгж (Аялал жуулчлалын алба) сумдад газрын даргын тушаалаар томилогдсон байгаль хамгаалагч ажиллана.

2.4. Суманд ажиллах байгаль хамгаалагчдыг сумын Засаг даргын санал, Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжыг үндэслэн томилж чөлөөлөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

2.5. Суманд ажиллах идэвхитэн байгаль хамгаалагчийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу томилох, чөлөөлөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

2.6. Газрын орон тоо 50 бөгөөд удирдах 3, гүйцэтгэх 42, үйлчлэх 5 ажилтантай байна. Газар дотор ойн алба, аялал жуулчлалын алба нь тус бүр удирдах 1, гүйцэтгэх 2 ажилтантай байна.

2.7. Газрын дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.7.1. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалтын дагуу тушаал гаргах, биелэлтийг хангуулах, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.7.2. Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалтын дагуу төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.7.3. Газрын мэргэжилтнүүд, нэгжүүдтэй бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар төрийн захиргааны албан хаагчтай үйл ажиллагааны төлөвлөгөө, үйлчилгээний албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ тус тус байгуулж, үр дүнг дүгнэх.

2.7.4. Газрын албан хаагчдыг зохих журмын дагуу томилох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.

2.7.5. Шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх.

2.7.6. Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах хамтран ажиллах.

2.7.7. Газрын үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг бүрэн хангах.

2.7.8. Сумын Засаг даргын Аймгийн засаг даргатай үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах байгаль орчин, аялал жуулчлалын ажлын чиглэл, шалгуур, үзүүлэлтийг сум сумын онцлогтой уялдуулан боловсруулж, Засаг даргад дэмжлэг үзүүлэх.

2.7.9. Газрын үйл ажиллагаатай холбогдолтой гарсан хууль, тогтоомж, УИХ, Засгийн газар, яам, агентлаг, болон орон нутгийн удирдах байгууллагын тогтоол, тушаал, шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах, хэрэгжүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө байгуулж, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар зохион байгуулах.

2.7.10. Газрын ажилтнууд, сум дундын болон сумын ойн ангийн инженер, техникийн ажилтан, байгаль хамгаалагч нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, давтан сургах, дадлага, туршлагажуулахад туслалцаа үзүүлэх.

2.8. Ойн албаны дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.8.1. Газрын дарга эзгүйд газрын даргыг орлоно.

2.8.2. Сум дундын болон сумын ойн ангиудыг харъяалах, удирдан чиглүүлэх, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, хянах

2.8.3. Ойн албаны даргыг эзгүйд орлох эрх авсан мэргэжилтэн орлоно

2.9. Аялал жуулчлалын албаны дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.9.1. Газрын дарга, Ойн албаны даргыг эзгүйд газрын даргыг орлоно.

2.9.2. Аялал жуулчлалын албаны даргыг эзгүйд орлох эрх авсан мэргэжилтэн орлоно

Гурав: Газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах

3.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.

3.1.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас гаргасан байгаль орчин, аялал жуулчлалын бодлого, хууль, тогтоомж, зарлиг, бодлогын баримт бичиг, хөтөлбөр төлөвлөгөө, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улс Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр нэгдэн орсон олон улсын конвенцийг хэрэгжүүлэх, мөрдүүлэх, сурталчлах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулна.

3.1.3. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр үндэсний болон орон нутгийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг тухайн жилийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх, хяналт тавих, бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг судалж аймаг, сум, орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж хэрэгжилтийг зохион байгуулна. Мөн сумын Засаг даргыг аймгийн Засаг даргатай үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдах арга хэмжээнүүдийн чиглэлийг гаргаж мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангана.

3.1.4. Байгаль орчин, аялал жуулчлалын зарим тулгамдсан асуудал бүрээр аймгийн дэд хөтөлбөр санаачлан боловсруулж батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3.1.5. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгагдсан арга хэмжээг хариуцан зохион байгуулах, сумдыг

мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

3.1.6. Байгаль орчин, байгалийн нөөц, аялал жуулчлалын мэдээллийн аймгийн санг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүрдүүлэх, тайлан мэдээ гаргах, "Байгаль орчны хамгаалах тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтуудыг жишиг болгон байгаль орчны мэдээллийн улсын сангийн мэдээ, баримтыг бүрдүүлэн Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хуулийн хугацаанд хүргүүлэх үйл ажиллагааг эрхлэн холбогдох байгууллага, иргэдэд шаардлагатай мэдээллээр үйлчилэх.

3.1.7. Байгаль орчин, аялал жуулчлалтай холбогдолтой судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах.

3.1.8. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоох, зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглуулах.

3.1.9. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн болон усны нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангуулах, байгаль хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах.

3.1.10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төслүүдийг үнэлгээнд бүрэн хамруулах, аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж хуулийн дагуу эрх үүргийнхээ хүрээнд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийн талаархи тайланг жил бүр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлнэ.

3.1.11. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэ ажилд байгууллага, иргэдийн хүч оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

3.1.12. Нутгийн ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Байгаль орчныг хамгаалах болон аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулан мэргэжлийн ажилчдыг сургах, давтан сургах, боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх.

3.1.13. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг авах. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх, түүнд холбогдох талуудын оролцоог хангах ажлыг зохион байгуулах.

3.1.14. Байгаль хамгаалагчдыг мэргэжлийн удирдлагаар тогтмол хангаж, тэдний үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ноогдуулах, байгаль хамгаалагчдыг бие хамгаалах техник хэрэгсэл, унаагаар хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

3.1.15. Шинжлэх ухаан, технологи, экологийн цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай шинжлэх ухааны төслийн захиалга авч, нэгдсэн саналаа удирдах дээд байгууллагад танилцуулан хөрөнгө мөнгийг шийдвэрлүүлэх, дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллана.

3.1.16. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялгийн ашиглалт, хэрэглээнд тогтмол хяналт шинжилгээ хийж, нөөцийн тоо, хэмжээний тухай мэдээлэл бүрдүүлэх, энэ ажилд иргэд, нөхөрлөлийн оролцоог хангах, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, бэлтгэх нөөцийн үндэслэлийг боловсруулах, ашиглах дээд хязгаарыг тогтоох саналаа яаманд хүргүүлэх, эрх, үүргийнхээ хүрээнд мөрдүүлж ажиллах, улсын захиалга даалгаварт ажлын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах.

3.1.17. Байгалийн нөөц баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, байгаль орчны

төлөв байдалд хяналт шинжилгээ хийх.

3.1.18. Байгаль орчныг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, үүний дотор ойжуулалт, ойн аж ахуй арга хэмжээг хэрэгжүүлэх, байгальд халгүй хаягдалгүй технологи нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд болон ой, ус, ургамал, ангийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах.

3.1.19. Орон нутгийн хэмжээнд ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд үнэлгээ хийх, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, зохион байгуулах, улсын захиалга, даалгаварт ажлын хэрэгжилтийг хангуулах.

3.1.20. Байгаль орчныг доройтол, бохирдлоос хамгаалах, тэдгээрт хяналт шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд ус цаг уур, орчны шинжилгээний албыг татан оролцуулах, хог хаяглал, химийн бодисын менежментийг хэрэгжүүлэх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан хохиролын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах, нөхөн төлүүлэхээр хууль хяналтын байгууллагад саналаа хүргүүлнэ, байгаль орчныг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, байгальд халгүй, хаягдалгүй, цэвэр технологи нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх.

3.1.21. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг орон нутгийн байгууллагатай уялдуулах, ТХГН-н талаарх төрийн бодлого, хууль тогтоомжыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгалийн нөөц, дурсгалт газрын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газрыг хамгаалах. /ТХГ/

3.1.22. Аймгийн ойн сангийн төлөв байдал, ой зохион байгуулалт, бүртгэл тооллогын ажлыг явуулж, өөрчлөлтийг тооцон мэдээлэх, ойн ашиглалт, хамгаалалтын бүс, хот суурин газрын ногоон бүсийг тогтооход санал өгөх, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ойн санг эзэмшүүлэх, ашиглуулах талаар баримт материал бүрдүүлэх, гэрээ байгуулах, батламжлуулахад мэргэжлийн дэмжлэг тусалцаа үзүүлэх, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэнд технологийн хяналт тавьж зөрчлийг арилгуулах.

3.1.23. Аймаг, бүс нутгийн уур амьсгал, байгаль орчин, орон нутгийн хэрэгцээ, онцлогт зохицсон, зохих материаллаг бааз бүхий мод сөөг, ургамалын үржүүлгийн газар байгуулах, үрийн нөөц сан бүрдүүлэх, тарьц суулгац ургуулж нөөц бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж сайн чанарын үр, тарьц суулгацаар орон нутгийн хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулах.

3.1.22. Аймаг, сумдын мод бэлтгэх талбайг тусгаарлах, мод бэлтгэлийн ажилд технологийн хяналт тавьж, мод бэлтгэсэн талбайг хүлээн авч дүгнэлт гаргах, мод модон

түүхий эд бэлтгэдэг мэргэжлийн байгууллагуудыг сонгон шалгаруулж, техник, технологийн өндөр түвшинд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулах, зах зээлд чанар сайтай мод, модон материал нийлүүлэх явдлыг дэмжих замаар хууль бусаар мод бэлтгэх явдлыг таслан зогсоох, орон нутгийн модны хэрэгцээг хангах ажилтай уялдуулан зохион байгуулах.

3.1.23. Нэн ховор ховордсон, ашигт болон эмийн ургамалыг тарималжуулах плантаци байгуулах, ургамлыг байгалийн нөхцөлд нь зориудаар үржүүлэх тарималжуулах ажлыг зохион байгуулах, тархац нөөцийн судалгааг хийж хамгаалалтын арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. /ой/

3.1.24. Усны нөөцийг хамгаалах зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Сав газрын захиргаатай болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хамтран зохион байгуулж ажиллах.

3.1.25. Усны нөөц, түүний зохистой ашиглалт хэрэглээний тоо бүртгэлийг хөтөлж усны бохирдол хомсдлын зэрэглэл, чанарыг тогтмол үнэлж усны мэдээллийн санд оруулах, гадаргын усны тооллого хийж, ширгэж хатсан гол горхи, рашаан, булаг, шандны тоо, мэдээллийг гаргаж холбогдох мэдээллийн сан байгуулж нэгдсэнтайланг дээд байгууллагад хүргүүлнэ.

3.1.26. Усны нөөц, эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч зарим гол нуурын усыг салаалах, бороо, цасны шар усыг тогтоон барих, хуримтлуулж усан сан, хөв, цөөрөм байгуулах, рашаан, булгийн эхийг хамгаалах, цэвэр ариун байлгах зэрэг ажлыг зохион байгуулах, мэргэжлийн удирдлага, заавар зөвлөмж өгнө.

3.1.27. Голын урсац бүрэлдэх эх, усны сан, ойн сан бүхий газрын хил заагийг тогтоох, хамгаалах, эдгээр газарт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лиценз олгогдсон эсэхэд хяналт тавих, булаг шанд рашаан, бүх төрлийн худгуудыг хариуцах эзэнтэй болгох ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, усны чиглэлийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах.

3.1.28. Гадаргын болон газрын доорх ус авах барилга байгууламж, гүний худгуудын ашиглалтад хяналт тавих, тоолууржуулах, эзэн хариуцагчтай болгох ажлыг хариуцан зохион байгуулах./УС/

3.1.29. Агаарын бохирдол, хог хаягдал, химийн бодисын менежмент, био аюулгүй байдлын асуудлаар бодлогын хэрэгжилтийг хангах, агаар, ус, хөрсийг бохирдлоос хамгаалах, хяналт шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд ус, цаг уурын орчны шинжилгээний албыг татан оролцуулах.

3.1.30. Ой хээрийн түймэр, байгалийн гамшигаас иргэдийн амь нас, байгалийн нөөц баялгийг урьдчилан сэргийлэх, хамгаалах багаж, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцтэй байх, ой, хээрийн түймрээс сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах.

3.1.31. Аюултай хог хаягдлын хуримтлал үүсгэхгүй байх, био аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулна. Хог хаягдлын орчин үеийн менежмент, технологийн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна./ХОГ/

3.1.32. Аялал жуулчлалын салбарыг тухайн орон нутагт хөгжүүлэх нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.

3.1.33. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сум орон

нутаг, аялалын маршрут боловсруулж зах зээлд нийлүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шинэ бүтээгдэхүүн бий болгох, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

3.1.34. Аялал жуулчлалын салбарын нөөцийн судалгаа хийх, мэдээллийн бааз бий болгох, статистик мэдээ гаргах.

3.1.35. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, жуулчны бааз, бусад үйлчилгээний газар, тур оператор, аж ахуйн нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдамж зөвлөгөөгөөр хангах, хяналт тавих.

3.1.36. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангана.

3.1.37. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ./АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ/

3.1.38. Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, зохион байгуулах."Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг жишиг болгон байгаль орчны мэдээллийн улсын сангийн мэдээ, баримтыг бүрдүүлэн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд хуулийн хугацаанд явуулах, статистик мэдээлэл нэгтгэж гаргах.

3.1.39. Газар зүйн мэдээлэлд суурилсан мэдээллийн сан хариуцана.

3.1.40. Байгалийн нөөц баялгийн талаарх мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн, холбогдох байгууллага, иргэдэд байгаль орчны мэдээллээр үйлчилэх.
/МЭДЭЭЛЛИЙН САН/

3.1.41. Байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээнавах.

3.1.40. Нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох, зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглуулах.

3.1.41.Хууль тогтоомжинд тусгайлан заагдсан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.2. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент, байгаль хамгаалал, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд:

3.2.1. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, аялал жуулчлалын менежментийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зөвлөмж аргачлалаар үйлчилнэ.

3.2.2. Байгаль хамгаалах нөхөрлөл байгуулахад мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, мэдлэг, чадвар эзэмшүүлнэ.

3.2.3. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэ ажилд байгууллага иргэдийн хүч оролцоо, хөрөнгө оруулалтын нэмэгдүүлэхэд ажлыг зохион байгуулна.

3.2.4. Нутгийн иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын дунд байгаль орчныг хамгаалах болон аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулан мэргэжлийн ажлчдыг сургах, давтан сургах боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлнэ. Ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах нөхөн сэргээх зохистой ашиглахад чиглэгдсэн сурталчилгааг байнга хийх.

3.2.5. Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах иргэдийн нөхөрлөлийг дэмжих, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх, гишүүдийн дунд сургалт зохион байгуулах, харилцан туршлага судлуулах ажлыг зохион байгуулна.

3.2.6. Аж ахуй нэгж, байгууллага, нөхөрлөл иргэдэд ойн санг эзэмшүүлэх, ашиглуулах талаар баримт материал бүрдүүлэх, гэрээ байгуулах менежментийн төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулахад дэмжлэг тусалцаа.

3.3. Удирдан зохицуулах, нийгмийн хамгаалал, ажлын үр дүнг үнэлж дүгнэх үйл ажиллагааны хүрээнд

3.3.1. Сумдын хэмжээнд хэрэгжүүлэх байгаль орчны арга хэмжээг жил, улирлаар төлөвлөн зохион байгуулахад сумдад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх удирдан чиглүүлнэ.

3.3.2. “Аймгийн Байгаль орчны төлөв байдлын тайлан”-г 2 жил тутамд боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3.3. Байгаль орчин, аялал жуулчлалын талаар аймгийн хэмжээнд хийгдсэн жилийн тайланг нэгтгэж аймгийн ИТХ-д танилцуулна.

3.3.4. Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт, хууль бус үйлдэлтэй тэмцэх аймгийн хэмжээний мэдээллийн сүлжээг холбогдох тусгай эрх бүхий төрийн байгууллагатай хамтарч байгуулж ажиллана.

3.3.5. Зэрлэг амьтны менежментийг хэрэгжүүлэх, зэрлэг амьтны хяналт шинжилгээ хийх журам боловсруулж хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, энэ ажилд нөхөрлөлүүдийг хамруулах ажлыг зохион байгуулна.

3.3.6. Зэрлэг амьтан үржүүлэх, агнуурын бүс нутаг тогтоох, ховордсон болон ашигт ургамал тарималжуулах нөхөрлөл, аж ахуй байгуулах газар нутгийн сонгох. Үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлнэ.

3.3.7. Төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх эжилд дэмжлэг үзүүлэх, иргэдийн хүч оролцоо хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжлийн байгууллага байгуулахад мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлнэ.

3.3.8. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр явуулах судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг тодорхойлох холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах, мэдээллийн санд оруулах, түүний дагуу төлөвлөлт, менежментийг хэрэгжүүлнэ. Байгаль орчин, байгалийн нөөц, аялал жуулчлалын мэдээллийн аймгийн санг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх, тайлан мэдээ гаргах, байгаль орчин, аялал жуулчлалын улсын нэгдсэн мэдээллийн санд оруулахаар хугацаанд нь хүргүүлэх үйл ажиллагааг эрхлэн, холбогдох байгууллага, иргэдэд шаардлагатай мэдээллээр үйлчилнэ.

3.3.9. Сумдад ажиллах идэвхтэн байгаль хамгаалагчдын томилох, оновчтой сүлжээг тогтоож, хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлэхэд иргэд, нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, тэднийг сургаж чадавхжуулна.

Дөрөв: Хамтын ажиллагаа

4.1. Байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх талаар бусад газар, агентлаг, ялангуяа газрын харилцаа, үйлдвэр, хөдөө аж ахуй уул уурхайн салбар